

БАТЛАВ

“ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ” ТӨХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ЛХАГВА-ОЧИР

2026 04 18
..... оны р сарын

БРЭНДБҮҮКИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ АЖЛЫН ДААЛГАВАР

Зорилго: Брэндийн өнгө төрхийг тодорхойлох, шинэчлэх

Зорилт: Компанийн 20 жилийн ойг угтан брэндийн өнгө төрхийг орчин үеийн шинэлэг загвараар бий болгон олон нийтэд таниулан сурталчлах, олон нийтэд хүргэх мэдээ мэдээлэл, зар сурталчилгаа, тараах материал, компанийн дотоодод ашиглагдах албан бичиг, бэлэг дурсгалыг материалууд гэх мэт маркетингийн элементүүдийг стандартжуулан дагаж мөрдөх.

Хугацаа: 1 сар

Төсөв: 18,000,000 төгрөг

ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ АЖЛЫН АГУУЛАМЖ:

№	Үзүүлэлт	Тайлбар
1	Брэндийн тойм:	- Эрхэм зорилго - Алсын хараа - Үнэт зүйлс - Брэндийн түүх
2	Логоны удирдамж:	- Логоны хувилбарууд - Лого хэрэглэх дүрэм (Компанийн тэгш ойн логоны загварыг нэмэлтээр батлуулах)
3	Өнгөний палитр:	- Брэндийн үндсэн болон хоёрдогч өнгөний багц - Дижитал (RGB, HEX) болон хэвлэх (CMYK, Pantone) зориулалттай тодорхой өнгөний код
4	Үсгийн загвар (Фонт):	- Үндсэн фонтууд - Фонт хэрэглэх дүрэм
5	Дүрслэлийн элементүүд:	- Зураглалын хэв маяг - График элементүүд
6	Брэндийг хэрэглэх жишээ:	Брэндийг төрөл бүрийн нөхцөлд хэрхэн ашиглах жишээ: 1. нэрийн хуудас (Загвар дизайн) 2. албан бланк, дугтуй 3. сав баглаа боодол, бэлэг дурсгалын материалууд 4. дижитал материал (вэб сайт, нийгмийн сүлжээ, и-мэйлийн загвар) 5. Зар сурталчилгаа (видео контент, фото зураг гэх мэт бүхий л форматууд) 6. Спортын хувцас
7	Цахим орчны удирдамж	- Нийгмийн сүлжээ, вэб сайтын загварыг шинэчлэн гаргах,

8	Хийж болох зүйлс ба хориотой зүйлс	- Брэндийг төлөөлөн гаргахад түгээмэл гардаг алдаанууд, тэдгээрээс хэрхэн зайлсхийх тухай гарын авлага, зөвлөмж
---	------------------------------------	---

Гүйцэтгэгчид тавигдах шаардлага:

- Өмнө нь бүрэн хэмжээний брэндбүүк боловсруулж, батлуулж байсан туршлагатай.
- Захиалагчийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн ажлын даалгаврын дагуу нэг баг болон захиалагчтай хамтран ажиллах,
- Төлөвлөгөөт хугацаанд боломжит хувилбарт саналуудыг боловсруулан танилцуулах бизнесийн ёс зүйн болон мэргэжлийн өндөр чадавхтай байх.

БОЛОВСРУУЛСАН:

МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИ, ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



Б.БАТБИЛЭГ

2026 оны 04 дүгээр сарын 16